



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны товч

Булган аймаг дахь шүүхийн тамгын газар нь 2020 онд 962750200 сая төгрөгийн төсөвтэйгөөр Булган аймаг дахь анхан болон давж заалдах шатны 11 шүүгч, 25 захиргааны ажилтны хүний нөөцөөр 1118 хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж төрийн санд 128761479 тэрбум төгрөг орууллаа.

Тодруулбал, Давж заалдах шатны шүүх 2020 оны эхний хагас жилийн байдлаар 29 эрүүгийн 29 хэрэг, иргэний 18 хэрэг, зөрчил, ял дүйцүүлэхийн 7 хэрэг, нийт 54 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэжээ.

Анхан шатанд эрүүгийн 139 хэрэг, иргэний 594 хэрэг, захиргааны 7 хэрэг, нийт 740 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, 271 зөрчил, зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулж, 29 хүнийг хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллаж, 24 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авчээ.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны товч

Тус шүүхийн Тамгын газраас 17 зорилт бүхий 26 арга хэмжээ бүхий нийт 110 ажил төлөвлөн хэрэгжүүлж ирсэн байна. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас 8 ажил байгаа бөгөөд короновирустэй холбоотойгоор сургалт, сурталчилгаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд мониторинг хийх ажил хангалтгүй хийгдсэн байна.

Тамгын газрын даргаас хуулиар хүлээсэн бүрэн эрхийн хүрээнд удирдлага зохион байгуулалт, төсөв санхүү болон бусад ажилтай холбогдуулан А-41, Б-22 тушаал, 4 удирдамж баталж, 238 албан бичиг хүлээн авч, 261 албан бичиг гадагш явуулсан байна.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд чиглэсэн үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан барелль үсгийн хавтас байрлуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай замыг шүүхийн байранд шинээр хийж байрлуулсан.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы видео мэдээллийг хүргэхээр ажиллаж байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд чиглэсэн үйлчилгээ

Булган аймаг дахь
Шүүхийн тамгын газар

НҮҮР ТАМГЫН ГАЗАР ИЛ ТОД БАЙДАЛ МЭДЭЭ СУРГАЛТ ХҮРЛЫН ЗАР ТОЙМ ШҮҮГЧ НАР

Home » Нүүр

Англи хэлний тэмцээн зохион байгууллаа
2020-06-25

Иргэний хэргийн шүүхэд хандах

Захиргааны хэргийн шүүхэд хандах

Эвлэрүүлэн зүүчлэл

Шүүх хурлын зар

Булган аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2020-07-06 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 10-ны өдрөөс	Булган аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2020-07-06 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дугаар сарын 10-ны өдрөөс	Иргэний хэргийн анхан шатны шүүх 2020-07-06 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс
--	--	---

Тус шүүхийн тамгын газраас 2020 онд өөрийн шүүхийн веб сайтыг шинэчилж ажилласан.

Shuukh.mn болон шүүхийн цахим хаяг, гадна, дотор мэдээллийн самбарт мэдээллийг тогтмол байршуулж хэвшсэн байна. Шүүхийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэдэд зориулсан иргэн, захиргааны хэргийн нэхэмжлэлийн бүрдүүлбэр, шүүхэд хүсэлт, нэхэмжлэл гаргах загвар, давж заалдах болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт, гомдол бичих загвар бүхий хавтасыг хийж шүүхийн үйлчилгээний хэсэгт байрлуулсан.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд чиглэсэн үйлчилгээ

Булган аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргах
нэхэмжлэлийн загвар

Д/д	Дугаар	Нэхэмжлэлийн загварын нэр
1		Улсын тэмдэгийн хураамж бодог аргачлал
2	Нэхэмжлэлийн загвар 1	Ажилласан жил тогтоолох тухай
3	Нэхэмжлэлийн загвар 2	Бичиг баримтын жинхэнэ эзэмшигчээр тогтоолох тухай
4	Нэхэмжлэлийн загвар 3	Нас тогтоолох тухай
5	Нэхэмжлэлийн загвар 4	Үрчлэлт хүчингүй болгуулах тухай
6	Нэхэмжлэлийн загвар 5	Суралгүй алга болсонд тооцуулах тухай
7	Нэхэмжлэлийн загвар 6	Хариуцагчийг эрэн сурвалжлуулах хаяг тогтоолох тухай
8	Нэхэмжлэлийн загвар 7	Нөхөх олговор гаргуулах тухай
9	Нэхэмжлэлийн загвар 8	Хамтын амьдралтай байснаа тогтоолох тухай
10	Нэхэмжлэлийн загвар 9	Садан төрлийн холбоотой болохыг тогтоолох тухай
11	Нэхэмжлэлийн загвар 10	Хүүхдийн тэтгэлэг тогтоолох тухай
12	Нэхэмжлэлийн загвар 11	Эзэлийн гэрээний үүрэг төгсөг гаргуулах тухай
13	Нэхэмжлэлийн загвар 12	Гэрлэлт цуцлуулах хүүхдийн тэтгэлэг, дундын эд хөрөнгөөс ногдох хэсгийг гаргуулах тухай
14	Нэхэмжлэлийн загвар 13	Ажилд элүүлэн тогтоолож ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах тухай
15	Нэхэмжлэлийн загвар 14	Гэрлэлт хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай
16	Нэхэмжлэлийн загвар 15	Эцэглэх тогтоолох хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай

Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн
2020 оны нэхэмжлэлийн загварын жагсаалт

Д/д	Дугаар	Нэхэмжлэлийн загварын нэр
1.	Нэхэмжлэлийн загвар-1	Төрийн албаны маргаан гажлаас үндэслэлгүй халагдсан!
2.	Нэхэмжлэлийн загвар-2	Төрийн албаны маргаан /цахим хуудсанд сонгон шалгаруулалт зарласантай холбоотой!
3.	Нэхэмжлэлийн загвар-3	Газрын маргаан /эзэмших эрхийн гэрчилгээтэй холбоотой!
4.	Нэхэмжлэлийн загвар-4	Газрын маргаан /дуудлага худалдаа зохион байгуулсантай холбоотой!
5.	Нэхэмжлэлийн загвар-5	Нийгмийн даатгалын маргаан /нийгмийн даатгалын хэлтсийн буруутай үйлдэл!
6.	Нэхэмжлэлийн загвар-6	Нийгмийн даатгалын маргаан /тэтгэмж олгохтой холбоотой!
7.	Нэхэмжлэлийн загвар-7	Ахт хүчингүй болгуулах /Улсын байцаагчийн акттай холбоотой!
8.	Нэхэмжлэлийн загвар-8	Тендерийн маргаан
9.	Нэхэмжлэлийн загвар-9	Улсын байцаагчийн акт /шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газартай холбоотой!
10.	Нэхэмжлэлийн загвар-10	Ашигт малтмалын маргаан
11.	Нэхэмжлэлийн загвар-11	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан
12.	Нэхэмжлэлийн загвар-12	Татварын улсын байцаагчийн акт
13.	Нэхэмжлэлийн загвар-13	Шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай /эерчлийн маргаан!
14.	Хүсэлт-1	Албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлт
15.	Хүсэлт-2	Хугацаа сэргээгдэх тухай хүсэлт

Товчоог бэлтгэсэн: Шүүхийн туслах /Г.Ангирмаа/



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд



Тус шүүхийн тамгын газраас хавтаст хэрэг илгээх хүлээн авах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд санал гаргаж, ШЕЗ-д хүргүүлсэн. Нийт шүүгч, шүүгчийн туслах, архивын ажилтныг лацаар хангасан байна. Цагдаагийн байгууллагатай лац хүлээлцэх бүртгэлийн дэвтрийг гаргаж, өдөр бүр лац хүлээлцэж хэвшсэн. 2-р улиралд “Эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-ын хэрэгжилтэнд хяналт хийж, эд мөрийн баримтын өрөөнд хадгалагдаж байгаа тодорхойгүй эд мөрийн баримтыг эрэн сурвалжлах ажиллагааг хийж, эд мөрийн баримтын зүүлтийг журмын дагуу хийсэн байдалд хяналтыг тавьж ажиллаж байна. Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд эд мөрийн баримт хүлээн авалт, шийдвэрлэлтийг хэрхэн хийж байгаад 17 хоног бүр хяналтыг тавьж ажиллаж хэвшсэн.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд




Иргэн, Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулахаар тус шүүхийн тамгын газраас ШЕЗ-д саналыг хүргүүлж ажилласан. Иргэн-2014 бүртгэл хяналтын нэгдсэн системийн сургалтыг 2 удаа явуулсан. 2020 оны хагас жилийн байдлаар Эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн системд даргалагч устгасан байдалд хяналт шалгалтыг хийсэн бөгөөд хагас жилийн байдлаар даргалагч устгасан тохиолдол гараагүй. Мөн түүнчлэн Иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд хэрэглэгчдийн алдаа зөрчлийн талаар 7 хоног бүрийн шуурхай хуралдаанаар хэлэлцсэнээр нэгдсэн системийн засварын тоо буурсан үзүүлэлтэй байна. Иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд шүүгч солих, чөлөөлөх ажиллагааг хэрэг хуваарилах журмын дагуу тохируулсан байдалд шалгалт хийж хяналтыг тогтмол тавьж ажиллаж байна.



Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Хугацаа хэтэрсэн хэрэг, түдгэлзүүлсэн хэргийн судалгааг 7 хоног бүрийн шүүгч ажилтны сонголд googledrive сан ашиглан танилцуулан ажиллаж байгаа бөгөөд өмнөх онд Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хугацаа хэтэрсэн хэрэг 3 байсан бол энэ онд мөн 3 хэрэг байна. Өмнөх онд түдгэлзүүлсэн хэрэг 22 байсан бол 2020 оны хагас жилийн байдлаар түдгэлзүүлсэн 37 хэрэг байгаа нь өмнөх оноос 40 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх өмнөх оны мөн үед 1 эрүүгийн хэрэг түдгэлзүүлсэн бол энэ онд 2 эрүүгийн хэрэг түдгэлзүүлсэн байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүх өмнөх онд 1 хэрэг түдгэлзүүлсэн байсан бол энэ онд 2 хэрэг түдгэлзүүлсэн байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны хагас жилийн байдлаар 340 шүүх хуралдаан товлогдсон бөгөөд 44 шүүх хуралдааны хойшлуулсан байгаа нь шүүх хуралдааны эзлэх хувь 12.9 хувь, 2020 оны хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шүүх 571 шүүх хуралдаан товлон зарласнаас 61 шүүх хуралдааныг хойшлуулсан нь нийт шүүх хуралдааны 10.6 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 141 шүүх хуралдаан товлогдсон бөгөөд 19 шүүх хуралдааны хойшлуулсан байгаа нь шүүх хуралдааны эзлэх хувь 13.4 хувь, 2020 оны хагас жилийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 193 шүүх хуралдаан товлон зарласнаас 30 шүүх хуралдааныг хойшлуулсан нь нийт шүүх хуралдааны 15.5 хувийг эзэлж байгаа нь 2.1 хувиар өссөн үзүүлэлттэй,

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 18 шүүх хуралдаан товлогдсон бөгөөд 8 шүүх хуралдааны хойшлуулсан байгаа нь шүүх хуралдааны эзлэх хувь 17.8 хувь, 2020 оны хагас жилийн байдлаар захиргааны хэргийн анхан шатны шүүх 5 шүүх хуралдаан товлон зарласнаас 1 шүүх хуралдааныг хойшлуулсан нь нийт шүүх хуралдааны 20 хувийг эзэлж байгаа нь 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй,


Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 37 шүүх хуралдаан товлосон бөгөөд 5 шүүх хуралдааны хойшлуулсан байгаа нь шүүх хуралдааны эзлэх хувь 14.7 хувь, 2020 оны хагас жилийн байдлаар Булган аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 49 шүүх хуралдаан товлосон бөгөөд 3 шүүх хуралдааны хойшлуулсан байгаа нь шүүх хуралдааны эзлэх хувь 6.1 хувь байгаа нь өмнөх оноос 8.6



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

харьцуулалт



он	ДЗШШүүх	ИХАШШүүх	ЭХАШШүүх	ЗХАШШүүх
2019 он хагас жил	14.7	12.9	13.4	17.8
2020 он хагас жил	8.6	10.6	15.5	20
Өсөлт/ буралт /-+/ %	6.1 -	2.3-	2.1+	2.2+



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж улирал бүр үнэлсэн. Ажлын байрны стандарт болон үйл ажиллагааны бүртгэл, материал архивлалтын үйл ажиллагааг хянаж, архивын материалыг эмхэлж цэгцэлсэн.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сурталчлах сургалт, нээлттэй өдөрлөг арга хэмжээг 8 суманд зохион байгуулж, 200 гаруй гарын авлага, сурталчилгааны материал тараав.

2020 оны эхний хагас жилд эвлэрүүлэн зуучлалаар 168 маргаан шийдвэрлэсний 66.6 хувь нь эвлэрэл амжилттай болж шүүхийн ажлын ачааллыг **20.1** хувиар бууруулсан байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар явагдсан 1789 шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр бүрэн, тасралтгүй бичин баталгаажуулж, архивласан байна.

Шүүгч ажилтнуудад Шүүхийн мэдээллийн технологийн талаарх мэдээ мэдээллийг шүүгч ажилтнуудад хүргэж ажилласан. **Зураг Уянга**



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн программаас иргэдийг сонгох ажиллагаа болон программ ашиглалт, хэрэгжилтийг сайжруулж, программын ажиллагаатай холбоотой саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлж ажилласан. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэгдсэн сургалтыг үр нөлөөтэй, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах ажлыг эхний хагас жилд 16 сумаас 8 сумын 89 иргэдийн төлөөлөгч нарт зохион байгуулж, сонгогдсон 150 иргэдийн төлөөлөгчид ил захидал, гарын авлагыг 2020 оны 1 сард хүргүүлж ажилласан. Нийт сонгогдсон 22 иргэдийн төлөөлөгч нараас шалтгаалан шүүх хуралдаан хойшилсон тохиолдол гараагүй болно.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

- Шүүхийн шийдвэр болон мэдэгдэх, гүйцэтгэх хуудас, бусад эрх зүйн баримт бичгүүдийг хэргийн оролцогчид, холбогдох байгууллага, иргэнд хуулийн хугацаанд хүргүүлж байгаад хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэх хуудасны бичилт, шийтгэврийн биелэлт зэрэгт тус тус шүүхүүд давхар хяналт тавьж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудасны бүртгэлийг 7 хоног бүрийн шүүгч ажилтнуудын сонсголд танилцуулан, улирал бүрээр ШШГГазарт хүргүүлж ажиллаж байгаа бөгөөд Булган аймаг дахь ШШГГазраас гүйцэтгэх хуудасны биелэлтийг ирүүлж ажиллаж байна. Шүүхийн 7 хоног бүрийн хэргийн хөдөлгөөний мэдээлэл Google drive ашиглан шийвэр гүйцэтгэлийн сан бүрдүүлж байна.
- 2020 онд шүүхийн тамгын газар нь бичиг хүргэгчийн ажлын ачаалал болон хүргэсэн бичиг хүргэлтийн мэдээллийг шүүгч ажилтнуудын сонсголд тогтмол танилцуулж хэвшлээ. Энэ мэдээлэлд хэдэн эрх зүйн актыг шуудангаар биечлэн хүргэсэн хэдэн эрх зүйн акт байгаа талаар нэг бүрчлэн танилцуулан ажиллаж байна. Булган аймаг дахь шүүхийн тамгын газраас 2020 оны эхний хагас жилд нийт 2691 бичиг хүргэсэн бөгөөд үүнээс 1917 бичгийг шуудангаар хүргүүлсэн байна. Бичиг хүргэгчийн судалгаанд үндэслэн хөдөөгийн багт хүргэлттэй тохиолдолд шатахууны зардал олгож шийдвэрлэж байна. Шүүгч, ажилтнуудын дунд бичиг хүргэлтийн судалгааг танилцуулсан бөгөөд шүүхүүдээс бичиг хүргэлттэй холбоотой гомдол санал гараагүй.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

2020 онд тус шүүхийн тамгын газраас Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах 35 ажил бүхий төлөвлөгөөг шинэчлэн баталсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар 88.5 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан алба хаагчдын хувьд ахлах байцаагч 1, хамгаалалтын цагдаа 2, харуулын цагдаа 4 нийт 7 орон тоотойгоос 2020 оны эхний хагас жилд ахлах байцаагч 1, хамгаалалтын цагдаа 2, харуулын цагдаа 3, нийт 6 алба хаагчтайгаар үүрэг гүйцэтгэж ажилласан.

Тус шүүхийн байранд 2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар **2178** шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн бичиг баримтыг шалган энгэрийн тэмдэг зүүлгэн, зохих журмын дагуу нийт 1432 иргэнийг нэвтрүүлэн, “Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах журам”-д заасны дагуу шүүх хуралдаанд оролцож байгаа хэргийн оролцогчид болон шүүгч, шүүхийн захиргааны ажилчидтай уулзах иргэдийг согтуурлын зэрэг тодорхойлох драгер багаж, гар металл илрүүлэгчээр шалган нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж хэвшлээ.

Давхардсан тоогоор **235** удаа яллагдагч, шүүгдэгчийг Цагдан хорих байрнаас шүүх, шүүхээс цагдан хорих байрлуу хуяглан хүргэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу ямар нэгэн зөрчил дутагдалгүй гүйцэтгэсэн.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Цагдаагийн байгууллагатай хамтран шүүх, шүүгчийн аюулгүй байдлын талаар 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах бүртгэл тайлангийн системийн үйл ажиллагааг жигдрүүлэх талаар ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаж байна. Албадан ирүүлэх ажиллагааны чанар нийт 54 албадан ирүүлэх захирамж гарснаас 49 нь биелэгдэж 5 албадан ирүүлэх ажиллагааны захирамж биелэгдээгүй ба 90.7 хувийн биелэлттэй байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2020 оны хагас жилийн байдлаар 3 албадан захирамж гарснаас 3 биелэгдсэн, 1 эрэн сурвалжлах захирамж гарснаас 1 биелэгдээгүй үзүүлэлттэй байна. Албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагааны биелэлтийн мэдээг 7 хоног бүр гаргаж нийт шүүгч ажилтнуудад танилцуулан ажиллаж байна.

2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Тагнуулын Ерөнхий газрын Булган аймаг дахь Тагнуулын газрын мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн а/д Г.Алзахгүйбаатар нь “Монгол улсын төрийн болон албаны нууц”-ын тухай сургалт зохион байгуулав. Сургалтанд захиргааны ажилтнууд хамрагдлаа. Түүнчлэн 2019 оны 04 дүгээр сард нийт шүүгч ажилтнуудаас нууцын баталгааг гаргуулан авч ажиллалаа. 2020 онд шинээр нууцын дардсыг хийлгэж ажилласан. Тус шүүхэд ирсэн нууцын зэрэглэлтэй хэрэгт нууцтай танилцах эрх бүхий алба хаагч нарыг томилуулахаар ТЕГ-т материалыг хүргүүлж ажилласан.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах ажлын хүрээнд

Архивын баримтыг Архивын ажиллах заавар, байгууллагын архивын ажиллах зааврын дагуу стандартын шаардлага хангасан чийг, гэрэл болон дулааны горимыг сайтар хянан хэмжин бүртгэн хөтлөн ажиллаж шаардлага гарвал зохих албан хаагчид хэлж тухай бүрт нь арга хэмжээ авч ажиллаж байна.

Тус шүүхийн салбар архивт нийт **17547** хадгаламжийн нэгж байна. Тус шүүхийн архивч нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид **1** удаа лавлагаа хуулбартай аж ахуйн нэгж байгууллагад тодорхойлолт гарган өгч **667500** төгрөгийн орлогыг Шүүхийн ерөнхий газрын зөвлөлийн дансанд төвлөрүүлсэн байна. Цахим архив ажлын хүрээнд 2398 хадгаламжийн нэгжийн 300403 хуудас баримтыг сканнердсэн.

- 1953-2019 оны хоорондох байнга хадгалах өнгөн хувиуд
- 1960-2019 оны хоорондох тамгын газрын даргын тушаал, бүтэн жилийн мэдээ
- 2000-2019 оны шүүн таслах ажиллагааны бүтэн жилийн мэдээ
- 1994-2003, 2015-2019 оны хоорондох иргэний хэрэг
- 2015-2019 оны хоорондох захиргааны хэрэг
- 1953-1995 оны хоорондох өнгөн хувиудад албан бичиг, цахилгаан зэрэг түр хадгалах баримтыг цуг хавтасласныг салгасан.

-1953-1999 оны хоорондох өнгөн хувиудад 250-аас дээш хуудастай баримт байсныг салган хавтасласан.

-Хуучирч муудсан хавтаснуудыг бүгдийг сольсон

- Тоос шороотой баримтыг нэг бүрчлэн цэвэрлэж тоосноос нь салгасан.

-урагдсан, хугарч нугарсан 125 хуудас баримтад сэлбэн засах ажлыг хийсэн.

Сканнердах явцад хөгцөрсөн болон хорхой шавжид идэгдсэн баримт байхгүй байсан. 14

хадгаламжийн нэгжийн 3473 хуудас баримтыг фото шал программээр эсвэрлэсэн.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгсөн албан хаагчдаар орон тоог бүрдүүлэх ажлыг шүүхийн тамгын газраас удаа дараа зохион байгуулж байгаа бөгөөд эхний хагас жилд шүүхийн үйлчилгээний хэлтсийн дарга, шүүгчийн туслах, мэдээлэл технологийн мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын төрийн албаны тусгай шалгалтыг зарлуулахаар төрийн албаны зөвлөлийн ШЕЗ-ийн салбарт орон тооны захиалгыг хүргүүлэн ажиллаж байна. Шүүхийн захиргааны ажилтнуудаас төрийн захиргааны ажилтнуудтай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж сар, улирлаар тайланг авч, дүгнэж ажиллалаа.

Шүүхийн захиргааны ажилтнуудын хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийж, шинээр томилогдсон 4 албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлэн ажиллаж байна. Шүүхийн хүний нөөцийн программд 36 шүүгч, ажилтны мэдээллийг цаг тухайд нь оруулж ажиллалаа.

Тус шүүхийн тамгын газраас шүүгч ажилтны ээлжийн амралтыг олгохдоо шүүн таслах ажиллагаа тасралтгүй явагдах зарчмын хүрээнд нийт шүүгч ажилтны ээлжийн амралтыг баталж, батлагдсан хуваарийн дагуу ээжлийн амралтыг олгож ажиллаж байна. Шүүгч, ажилтнуудад чөлөө олгосон 36 шийдвэрийг шүүхийн хүний нөөцийн программд тухай бүр оруулж ажилласан.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Тус шүүхийн тамгын газрын дарга Төрийн албаны тухай хуулиар 5 удаагийн 5 сэдэв бүхий сургалтыг нийт шүүхийн захиргааны ажилтнуудад зохион байгууллаа. 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр шүүгчийн туслах Г.Ангирмаа “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгууллаа. Тус сургалтанд шүүхийн захиргааны ажилтнууд хамрагдсан. Шүүхийн захиргааны ажилтны нэгдсэн холбоотой хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2019 оны шилдэг ажилтнаар бичиг хүргэгч П.Цогтбаатар шагнагдсан.

Түүнчлэн шүүгч, ажилтныг идэвхжүүлэх ажлын хүрээнд 020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр сургагч багш С.Болоргэгээ “Хувь хүний хөгжил төлөвшил” сэдвээр сургалт хийв. Сургалтанд шүүгч, захиргааны ажилтнууд хамрагдсан.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Тус шүүхийн тамгын газраас шүүгч ажилтны мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд англи хэлний сургалтыг 1 жилийн хугацаатайгаар зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд 2020.06.22-ны өдөр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын дунд “Англи хэлний мэдлэг сорих” тэмцээнийг зохион байгуулсан.

“Миний жолоо” авто курсын хууль дүрмийн багш Ш.Дуламсүрэн нь “Замын хөдөлгөөний дүрэм” сэдвээр 70 цагийн сургалт зохион байгуулж ажиллаж байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

2020 онд Булган аймаг дахь шүүхийн тамгын газар нь Монголын Хуульчдын холбоот хамтран эрх зүйн онолын болон практик судлал хосолсон 178 ширхэг ном хандивласныг номын сандаа байршуулан ажиллаж байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан шүүхийн захиргааны ажилтнуудын гэр бүлийг оролцуулсан “Шүүхийн нэг өдөр” уулзалт-өдөрлөг хийж шүүхийн үйл ажиллагаа болон захиргааны ажилтнуудын ажлын ачаалал, шүүхийн үйлчилгээний онцлогын талаар танилцуулга хийлээ. Уг арга хэмжээнд оролцсон 9 гэр бүлийн дунд зохион байгуулсан “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээнд мэдээлэл технологийн ажилтын Э.Уянгын гэр бүл ялагчаар шалгарсан байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Тус шүүхийн тамгын газар нь шүүхийн залуучуудын зөвлөлтэй хамтран шүүхийн сүүдрэвч, замыг засч тохижуулж байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн хүний нөөц

Тус шүүхийн тамгын газар нь шүүгч, ажилтны нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд шүүхийн захиргааны 20 ажилтанд ажлын дүрэмт хувцсын 50 хувийн хөнгөлтийг үзүүлж ажиллалаа. Түүнчлэн шүүгч, ажилтны зуслангийн хашааг барих ажлыг дэмжиж хамтран ажилласан байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах

Тус шүүхийн тамгын газраас covid-19 короновирус өвчин гарсантай холбогдуулан УОК-т 1 өдрийн цалингаа хандивласан. Шинэ коронавирусын халдвар /Covid-19)-оос урьдчилан сэргийлэх зорилгоор тус шүүхийн шүүгч, захиргааны ажилтнууд Булган сумын Онцгой комисст 70 ширхэг маск хандивласан.

Сайхан монгол телевизээр шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд хүргэсэн. Түүнчлэн Булганы мэдээ сонинд Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Г.Мягмарсүрэнгийн ярилцлага болон 1 дүгээр улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ тайланг олон нийтэд хүргэж ажиллалаа.

Өөрсдийн боловсруулсан “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын хуудсаар 1 дүгээр улиралд 32 хүн, 2 дугаар улиралд 181 хүнээс санал асуулга авч нэгтгэн дүгнэсэн.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах

Булган аймаг дахь шүүхийн тамгын газар нь эхний хагас жилийн байдлаар 6 удаагийн “шүүхэд баярлалаа” сэдвээр мэдээлэл бэлтгэсэн бөгөөд үүнээс 1 “шүүхэд баярлалаа” нь видео хэлбэрээр бэлтгэсэн нь шинэлэг болсон байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах

Тус шүүхийн тамгын газраас Шүүхэд мэдүүлэх эрхийг сурталчилах, хялбаршуулсан материал бэлтгэх ажлын хүрээнд Иргэн, Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах загвар, улсын тэмдэгтийн хураамж, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, давж заалдах болон эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт, гомдол гаргах загвар бүхий хавтсыг шинээр хийж шүүхийн үйлчилгээний хэсэгт байршуулсан. Түүнчлэн 7 сумын ЗДТГ-ын эрх зүйн хөтөч нарт дээрх шүүхэд мэдүүлэх эрхийн загвар бүхий хавтас, шүүхэд мэдүүлэх эрх болон эрх зүйн зөвлөмжийг 635 гарын авлагыг иргэд, эрх зүйн хөтөч нарт хүлээлгэн өгч ажиллалаа.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн нээлттэй байдлыг хангах олон нийттэй харилцах

2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран Булган аймгийн “Зорилтод бүлэг болох А2” бүлгийн иргэдэд “Зөрчлийн хэрэг болон эрүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалтыг зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн орсон байна.





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

Шүүхийн санхүү, дэд бүтэц хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга ХЭМЖЭЭ

Эхний хагас жилийн байдлаар		
Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
484,463,400.00	468,356,925.42	16,106,474.58

Ковид өвчний улмаас урсгал засвар, нэг удаагийн буцалтгүй тусламж, хичээл үйлдвэрлэлийн дадлага, гадаад томилолт зэрэг тэвчих зардлууд буцаан татсан. Оны эхнээс бичиг хэргийн зардал хэтэрч эхэлсэн. Хагас жилийн байдлаар 10,311,503.93 төгрөгийн өртэй гарсан.

Үүнд:

- Цалин – 7,326,558
- Шуудан холбоо – 1,155,307.39
- Гэрэл цахилгаан – 178,642.54
- Бичиг хэрэг – 1,650,996
- Ном хэвлэл – 64,000
- Газрын төлбөр -15,947

Үүнтэй холбоотойгоор ШЕЗ-д 3 удаа албан хүсэлт явуулсаны дагуу цалин 7 сараас 4 сая төгрөгөөр нэмэгдэж бусад зардлуудыг шийдэх боломж байна. Ковидтой холбоотой орлогын төлөвлөгөө алдагдсан дахиж төсөвт тодотгол хийж төсөв дахин буурах гэж байгаатай холбогдуулан төсвийн удирдаж хэмнэлт гарган ажиллахыг сануулсан.

Төсвийн ил тод байдлыг хангахын тулд шилэн дансны нэгдсэн цахим системд хуулийн хугацаанд 76 мэдээллийг оруулж тайлагнасан.

Хагас жилийн хөрөнгийн тооллогыг ӨХБЗ тоолсоны дагуу цаашид ашиглах боломжгүй 12,051,901.44 төгрөгийн хөрөнгийг акталж данснаас ашиглалтын хугацаа дууссан ч цаашид ашиглах боломжтой 147,803,639.78 төгрөгийн хөрөнгийг дахин үнэ тогтоох санлыг ТӨБЗГ-луу хүргүүлсэн.

ШЕЗ-өөс 12ш компьютер, 1ш принтер хувиарласан.

АНХААРАЛ ХАНДУУЛСАН
БАЯРЛАЛАА